



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Ахлах аудитор: О.Нарангарав Цахим хаяг: narangaravo@audit.gov.mn	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
---	--	---

1.Аудитын санал дүгнэлт



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.01.29 № 4-6/18
танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д.ЭНХТАЙВАН
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Батлагдсан төсвийн зардлыг эдийн засгийн ангилал зөрчин зориулалт бусаар зарцуулсан 2,676.4 мянган төгрөг, хөтөлбөр арга хэмжээ болон байгууллагын үндсэн данснаас нэмэлт данс хооронд зардлыг гүйлгэн 1,489.6 мянган төгрөгийг тус тус зарцуулж, залруулаагүй зөрчлийн нийт дүн 4,165.9 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин болох 2,029.2 мянган төгрөгөөс их байгаа нь өөрчлөлттэй дүгнэлт өгөх үндэслэл бүхий байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглагдаж байгаа элэгдлээ нөхсөн 2,482.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлээс хасаж, холбогдох тушаал шийдвэрийн дагуу 1,066.8 мянган төгрөгөөр дахин үнэлэн бүртгэн тайлагнасан байна.

010020198

Аудитын гол асуудал

Байгууллагын шилэн дансанд байршуулвал зохих 243.9 сая төгрөгийн 69 мэдээллээс 143.2 сая төгрөгийн 48 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 5.7 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулсан хэрэгжилт 91.5%-тай, хугацаа хоцролт 65.2%-тай байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,004,264.88	20,784,680.16
33	АВЛАГА	2,322,628.88	14,096,554.16
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	328,860.00	924,285.28
335	Бусад авлага	1,993,768.88	13,172,268.88
3351	Байгууллагаас авах авлага	1,993,768.88	3,872,268.88
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	9,300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,681,636.00	6,688,126.00
354	Хангамжийн материал	4,681,636.00	6,688,126.00
35410	Бичиг хэргийн материал	1,029,300.00	2,054,800.00
35420	Аж ахуйн материал	3,652,336.00	4,593,326.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	40,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	32,044,714.34	41,578,428.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	32,044,714.34	41,578,428.52
392	Биет хөрөнгө	31,839,380.94	41,417,095.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,111,111.14	27,111,111.14
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,694,444.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,890,208.00	9,750,680.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,372,129.08)	(1,174,799.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,153,190.15	9,351,980.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,992,999.27)	(1,977,432.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,000,000.00	4,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,000,000.00)	(4,000,000.00)
39217	Ном	50,000.00	50,000.00
393	Биет бус хөрөнгө	205,333.40	161,333.42
39301	Програм хангамж	352,000.00	352,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(146,666.60)	(190,666.58)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	39,048,979.22	62,363,108.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,636,494.00	765,540.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,636,494.00	765,540.00
413	Өглөг	1,636,494.00	765,540.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,636,494.00	739,540.00
4136	Бусад өглөг	-	26,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	26,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	37,412,485.22	61,597,568.68
51	Засгийн газрын хувь оролцоо	37,412,485.22	61,597,568.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,768,306.99	11,768,306.99
51101	Өмч: - төрийн	11,768,306.99	11,768,306.99
512	Хуримтлагдсан үр дүн	25,644,178.23	49,829,261.69
51210	Өмнөх үеийн үр дүн	25,644,178.23	25,644,178.23
51220	Тайлант үеийн үр дүн	-	24,185,083.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	39,048,979.22	62,363,108.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	187,737,673.64	286,423,446.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,066,760.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,066,760.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,066,760.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,066,760.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	187,737,673.64	285,356,686.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,893,300.00	58,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,893,300.00	58,050,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,844,373.64	227,306,686.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,844,373.64	227,306,686.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	185,689,446.29	262,238,363.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	185,689,446.29	262,238,363.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	180,446,546.29	255,458,363.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	86,519,170.15	136,710,130.60
210101	Үндсэн цалин	56,819,635.82	76,605,520.98
210102	Нэмэгдэл	12,890,297.33	35,781,159.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,689,000.00	9,120,000.00
210104	Урамшуулал	15,120,237.00	15,203,450.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,979,812.61	19,529,736.10
210201	Тэтгэврийн даатгал	8,882,763.29	14,926,573.02
210202	Тэтгэмжийн даатгал	805,371.71	1,154,010.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	644,217.11	923,208.74
210204	Ажилгүйдлийн даатгал	148,093.92	217,921.69
210205	Эрүүл мэндийн даатгал	1,499,366.58	2,308,021.73
2104	Хангамж, бараа материалын зардал	3,892,461.00	8,538,608.92
210401	Бичиг хэрэг	1,251,098.00	2,859,760.00
210402	Тээвэр, шатахуун	2,003,000.00	3,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	638,363.00	700,821.92
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,778,027.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	617,700.00	2,850,499.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	229,700.00	482,499.99
210604	Урсгал засвар	388,000.00	2,368,000.00
2107	Томилолт, зочны зардал	247,600.00	2,652,700.00
210702	Дотоод албан томилолт	247,600.00	2,652,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,536,756.00	69,077,563.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,521,556.00	68,940,017.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	15,200.00	63,296.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,653,046.53	16,099,124.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,710,147.00	13,573,579.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,942,899.53	2,525,545.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,242,900.00	6,780,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,242,900.00	6,780,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,242,900.00	6,780,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,048,227.35	24,185,083.46
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,631,242.21	24,185,083.46

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	188,138,381.64	287,350,455.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	188,138,381.64	287,350,455.78
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,294,008.00	60,043,768.88
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,893,300.00	58,050,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	400,708.00	1,993,768.88
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,844,373.64	227,306,686.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,844,373.64	227,306,686.90
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	183,693,812.76	275,625,465.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	183,693,812.76	275,625,465.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177,018,812.76	264,753,196.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	85,073,212.76	137,337,419.94
210101	Үндсэн цалин	53,225,100.41	75,362,004.57
210102	Нэмэгдэл	13,607,933.90	36,257,834.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,689,000.00	9,120,000.00
210104	Урамшуулал	16,551,178.45	16,597,581.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,361,013.88	21,440,246.04
210201	Тэтгэврийн даатгал	7,514,402.56	15,830,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	742,929.71	1,536,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	594,183.11	1,229,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	135,685.92	265,446.04
210205	Эрүүл мэндийн даатгал	1,373,812.58	2,578,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,833,338.00	9,642,487.92
210401	Бичиг хэрэг	2,491,975.00	3,448,760.00
210402	Тээвэр, шатахуун	1,703,000.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	638,363.00	696,421.92
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,997,306.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	573,700.00	2,417,000.00
210604	Урсгал засвар	344,000.00	2,417,000.00
2107	Томилолт, зочны зардал	820,200.00	2,652,700.00
210702	Дотоод албан томилолт	820,200.00	2,652,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,297,535.12	77,400,543.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,229,343.12	77,262,997.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,192.00	63,296.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,059,813.00	13,862,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,059,813.00	13,862,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,675,000.00	10,872,268.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,675,000.00	7,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,675,000.00	7,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,872,268.88
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэн шилжүүлэг	-	3,872,268.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,444,568.88	11,724,990.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,450,800.00	11,724,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,450,800.00	11,724,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,450,800.00	11,724,990.00
222001	Тоног төхөөрөмж	2,450,800.00	5,999,990.00
223001	Бусад хөрөнгө	-	5,725,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,450,800.00)	(11,724,990.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,768,306.99	88,298.80	(5,340,132.92)	6,516,472.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	88,298.80	88,298.80
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(88,298.80)	-	(88,298.80)
Тайлант үеийн үр дүн	-	-	30,896,012.35	30,896,012.35
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,768,306.99	-	25,664,178.23	37,412,485.22
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,768,306.99	-	25,664,178.23	37,412,485.22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	24,185,083.46	24,185,083.46
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,768,306.99	-	49,829,261.69	61,597,568.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	253,652,600.00	227,306,686.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	253,652,600.00	227,056,696.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	246,652,600.00	220,056,696.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,450,500.00	137,337,419.94
210101	Үндсэн цалин	84,668,000.00	75,362,004.57
210102	Нэмэгдэл	34,284,800.00	36,257,834.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,024,000.00	9,120,000.00
210104	Урамшуулал	34,473,700.00	16,597,581.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,175,100.00	21,440,246.04
210201	Тэтгэврийн даатгал	16,777,100.00	15,830,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,599,500.00	1,536,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,279,600.00	1,229,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	319,900.00	265,446.04
210205	Эрүүл мэндийн даатгал	3,199,000.00	2,578,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,802,000.00	9,642,487.92
210401	Бичиг хэрэг	3,500,000.00	3,448,760.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	730,000.00	696,421.92
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,997,306.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,500,000.00	13,892,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	5,750,000.00
210602	Тавилга	6,000,000.00	5,725,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,417,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,652,700.00
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,652,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,505,000.00	21,229,043.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,250,000.00	21,091,497.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,000.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,000.00	63,296.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,220,000.00	13,862,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,220,000.00	13,862,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,000,000.00	7,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,000,000.00	7,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.00	7,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	249,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	249,990.00
222001	Тоног төхөөрөмж	-	249,990.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	253,652,600.00	227,306,686.90
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	253,652,600.00	227,306,686.90
132001	Орон нутгийн төсвөөс	253,652,600.00	227,306,686.90
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	4.00	4.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	2.00	2.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	60,043,768.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	60,043,768.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	56,171,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	56,171,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	56,171,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,872,268.88
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,872,268.88
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэн шилжүүлэг	-	3,872,268.88
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,993,768.88
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	60,043,768.88
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	60,043,768.88
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	58,050,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,993,768.88

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23.2 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 19.1 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 4.1 сая төгрөгийн зөрчилд 4.1 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Аудитын явцад залруулсан алдаа:

1. Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан худалдан авсан 11.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн бусад хөрөнгийн зардал дансанд тайлагнаагүй, нэмэлт дансанд буцаан олгосон өмнө оны үлдэгдэл төвлөрүүлэлт 2.0 сая төгрөгийг орлогоор тайлагнаагүй алдааг тус тус залруулав.

2. Нийгмийн даатгалын тайланд 3 хүний урамшуулал 3.1 сая төгрөгт ногдох 0.7 сая төгрөгийн НДШ-ийн өр төлбөрийг бүртгээгүй, тайлагнаагүй орхигдуулсан, мөн 2.2 сая төгрөгийн АО-ийн төлөх НДШ-ийн зардлыг цалингийн зардалд бүртгэн тайлагнасныг залруулав.

3. Цалингийн зардлаас илүү шилжүүлсэн 924.3 мянган төгрөгийн ХХОАТ-ыг бүртгээгүй, үр дүнгийн тайлангаар цалингийн зардлыг 1,664.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.

3.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас өргөмжлөлийн хавтас хийлгэж 490.0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг АҮТХ-ийн зардлаас шагналын зардалд 708.0 мянган төгрөгийг, АО-НДШ-ийн зардлаас 1,478.4 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Мөн хөтөлбөр арга хэмжээ болон байгууллагын үндсэн данс болон нэмэлт данс хооронд зардлыг гүйлгэн зарцуулсан. Үүнд: Багийн ИНХ-ын даргын урамшууллын АО-НДШ-ийн зардлаас үндсэн үйл ажиллагааны цалингийн НДШ-д 432.1 мянган төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас Багийн ИНХ-ын цалингийн зардалд 612.6 мянган төгрөгийг, Үндсэн дансны цалингийн зардлаас нэмэлт дансны цалин буюу ОНЦ-ын ХХОАТ 444.9 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” журмын 4 дүгээр хавсралтын “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-тай, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” журамтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн албан шаардлага:

Батлагдсан төсвийн зардал, хөтөлбөр арга хэмжээний зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй байх

3.2 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын шилэн дансны сайтад байршуулбал зохих 243.9 сая төгрөгийн 69 мэдээллээс 143.2 сая төгрөгийн 48 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 5.7 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна. Хугацаа хоцролт 65.2%-тай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журамтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны сайтад байршуулбал зохих мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж байх

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн		
Орлого, зардлын гүйцэтгэлийг буруу бүртгэсэн	1	13,468.8	-	-	1	13,468.8	1	13,468.8	-	-	-	-
Цалингийн зардлыг буруу бүртгэсэн	1	2,589.0			1	2,589.0	1	2,589.0				
НДШ-ийн зардлыг буруу бүртгэсэн	1	3,002.2			1	3,002.2	1	3,002.2				
Дүн	3	19,060.0	-	-	3	19,060.0	3	19,060.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/							
			Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	4,165.9	-	-	1	4,165.9	-	-	-	-
Дүн	1	4,165.9	-	-	1	4,165.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		